



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/235

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, 48.2.9 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд нийтийн эзэмшлийн талбайд тарих модны тарьц, суулгац хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Гишүүд: Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)

Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)

Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын нярав)

Д.Ганзориг (Иргэний төлөөлөл)

2.Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг бүрэн хангуулж хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсэг (Б.Янжиндулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

